



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 6 сарын 28 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, 9.6.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Б.Нямдорж Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

А.Лхамсэржид Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Н.Нарантуяа Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Ц.Баярбат Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

Д.Бэлэгсайхан Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах ахлах мэргэжилтэн

2. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Яамны төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах болон албан хаагчдын ёс зүйтэй холбоотой аливаа асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Ёс зүйн зөвлөлд үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

08 00507

Барилга, хот байгуулалтын яамны  
Төрийн нарийн бичгийн даргын  
2019 оны 6 дугаар сарын 28-ны  
өдрийн 11/04 дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэм хэмжээг энэ журмаар зохицуулна.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэр Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Барилга, хот байгуулалтын яамны “Хөдөлмөрийн дотоод журам” болон бусад холбогдох хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

**Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг**

2.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий нийт 5 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байх ба “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6.2-т заасны дагуу төрийн албан хаагчдын саналыг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар гурван жилийн хугацаагаар томилно.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2 дахь хэсэгт заасан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, энэ дүрмийн 3 дахь хэсэгт заасан төрийн албан хаагчид тавих ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

2.3. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг томилох эрх бүхий этгээдийн бичгээр гаргасан шийдвэргүйгээр өөр албан тушаалтан орлохгүй.

2.4. Зөвлөлийн дарга дараахь чиг үүрэгтэй:

2.4.1. зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санал болгох, гишүүн, нарийн бичгийн даргын санал болгосон асуудлыг урьдчилан хянан үзэх, хэлэлцэх зөвшөөрөл олгох;

2.4.2. зөвлөлийн хуралдааныг товлох, удирдах, гишүүдийн асуулт асуух, санал, дүгнэлт хэлэх дарааллыг тогтоох;

2.4.3. хуралдаанд оролцож буй ёс зүйн зөрчил үйлдсэн /эсэх/, төрийн албан хаагч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, хариулт авах;

2.4.4. хэлэлцэж буй асуудлаар санал хурааж, дүнг мэдээлэх, дүгнэлтийг сонсох;

2.4.5. зөвлөлийн хуралдааны тэмдэглэлтэй танилцаж гарын үсэг зурах, зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид уучлал гуйхыг үүрэг болгох, сануулах хариуцлагыг хүлээлгэх тохиолдолд тогтоол гаргана.

2.5. Зөвлөлийн гишүүн дараахь чиг үүрэгтэй:

2.5.1. зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал болон хуралдааны товыг тогтоох талаар санал гаргах;

2.5.2. хуралдаанд оролцож буй ёс зүйн зөрчил үйлдсэн /эсэх/ төрийн албан хаагч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, хариулт авах;

2.5.3. хэлэлцэж буй асуудлаар санал хэлэх, санал хураалтад оролцож, тэмдэглэл, тогтоолыг сонсох;

2.5.4. зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, тогтоолтой танилцах;

2.5.5. хуралдааны үеэр түр гарах тохиолдолд хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.

2.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараахь чиг үүрэгтэй:

2.6.1. төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн асуудлаар холбогдох материалыг хүлээн авч судлан үзэж, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх;

2.6.2. хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах;

2.6.3. зөвлөлийн хуралдааны товыг дарга, гишүүд болон хуралдаанд оролцох ёс зүйн зөрчил үйлдсэн /эсэх/ төрийн албан хаагч болон холбогдох бусад хүмүүст зарлах;

2.6.4. хэлэлцэх асуудал, холбогдох материалыг хуралдаан эхлэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө зөвлөлийн даргад урьдчилан танилцуулж батлуулах;

2.6.5. хуралдаан эхлэхээс ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хуралдааны товыг зарлаж, холбогдох материалыг хүргэх;

2.6.6. хуралдаанд хүрэлцэн ирсэн зөвлөлийн гишүүдийн ирцийг бүртгэж танилцуулах;

2.6.7. хуралдаанд оролцож буй ёс зүйн зөрчил үйлдсэн /эсэх/ төрийн албан хаагч болон холбогдох бусад хүнээс асуулт асууж, хариулт авах;

2.6.8. хэлэлцэж буй асуудлаар саналаа хэлэх, санал хураалтад оролцож, дүгнэлтийг сонсох;

2.6.9. хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, дарга болон гишүүдийн гаргасан санал, тавьсан асуулт, мэдээллийг нэг бүрчлэн тэмдэглэлд тусгах;

2.6.10. зөвлөлийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, дүгнэлт эсхүл тогтоолыг албажуулан хуралдаан дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;

2.7. Зөвлөл үйл ажиллагаагаа Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлд хагас, бүтэн жил тутам тайлагнана.

#### Гурав. Зөвлөлийн хуралдаан

3.1. Зөвлөл хуралдааны үйл ажиллагааг тэгш, шударга, ардчилсан зарчмын үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулна.

3.2. Сайдын тушаалаар томилогддог болон яамны төрийн албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэх асуудлыг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Зөвлөлийн хуралдаанаар хянан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл хариуцлага хүлээлгэх тогтоол гаргана.

3.3. Зөвлөлийн тогтоолоор Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 4.2.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд уучлал гуйх хэлбэрийг тодорхойлсон байна.

3.4. Хуралдааныг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцно.

3.5. Зөвлөлийн хуралдаанд дараахь дэгийг баримтална:

3.5.1. хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар нарийн бичгийн дарга илтгэх;

3.5.2. ёс зүйн зөрчил гаргасанд тооцогдож буй төрийн албан хаагчийн дээд шатны албан тушаалтны бичгээр гаргасан тайлбарыг танилцуулах;

3.5.3. ёс зүйн зөрчил гаргасанд тооцогдож буй төрийн албан хаагч тайлбар хийх;

3.5.4. хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн дарга энэ журмын 3.5.3-т заасан төрийн албан хаагчаас асуулт асууж, хариулт авах;

3.5.5. шаардлагатай бол хэлэлцэх асуудалтай холбогдуулан бусад этгээдийн тайлбарыг сонсч, асуулт асууж, хариулт авах;

3.5.6. зөвлөлийн тогтоолын талаар гишүүд санал гаргах;

3.5.7. илээр санал хурааж, олонхи /50-иас дээш хувь/-ийн саналаар дүгнэлт гаргах;

3.5.8. зөвлөлийн дарга хуралдаанд тогтоолын агуулгыг танилцуулах;

3.6. Хэлэлцэх асуудалтай холбогдох албан тушаалтан, гэрч, бусад этгээдийг хуралдаанд оролцуулж болно.

3.7. Хуралдаанаар төрийн албан хаагч ёс зүйн хэмжээ зөрчсөн эсэх асуудлыг хэлэлцэж санал хурааж, хуралдаанд оролцогч гишүүдийн олонхийн саналаар тогтоол гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

3.8. Хуралдаанд ёс зүйн зөрчил гаргасанд тооцогдож буй төрийн албан хаагч болон бусад этгээд тайлбар хийх, асуултад хариулах, Зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг танилцуулахад байлцана.

3.9. Хуралдааны үйл явцын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд зөвлөлийн дарга шаардлагатай гэж үзвэл дүрс, эсхүл дууны бичлэг хийж болно.

3.10. Зөвлөлийн дарга тогтоолыг яамны Төрийн нарийн бичгийн дарга, тухайн албан хаагчийг шууд удирдах албан тушаалтанд танилцуулна.

Дөрөв. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах,  
шалгаж шийдвэрлэх

4.1. Сайдын тушаалаар томилогддог болон яамны албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

4.2. Сайдын тушаалаар томилогддог болон яамны албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээлэл, баримтыг Зөвлөлийн дарга хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дараахь журмын дагуу шалгалт зохион байгуулна:

4.2.1. гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх;

4.2.2. шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах, ажлын хэсэг байгуулах;

4.2.3. харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах.

4.3. Зайлшгүй нэмэлт шалгалт хийх, баримт цуглуулах шаардлагатай гэж үзвэл шалгалт явуулах хугацааг яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр 14 хоногоор нэг удаа сунгаж болно.

Тав. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх  
арга хэмжээ, нууцлал

5.1. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн албан хаагчдыг Ёс зүйн зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг танилцуулах, сурталчилах, сургалт явуулах зэрэг ажлуудыг жилд 1-2 удаа зохион байгуулна.

5.2. Танилцуулга, сурталчилгааг яамны дотоод сүлжээ, хэвлэмэл хуудсаар түгээнэ. Сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.3. Тухайн этгээд ёс зүйн зөрчил үйлдсэн эс үйлдсэнээс үл хамааран Төрийн болон албаны нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгална.

Зургаа. Бусад

6.1. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тогтоолыг зөвлөлийн дарга гарын үсэг зурж, Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн тэмдэг дарж баталгаажуулна.

6.2. Хуралдааны тогтоолыг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн тэмдэг дарж баталгаажуулна.

6.3. Хуралдаан, хуралдааны тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан "сонсох ажиллагаа"-нд тооцно.

6.4. Зөвлөлийн тогтоолыг тухайн албан хаагч эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу гомдол гаргаж болно.

6.5. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд жил тутам зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан албан тушаалынх нь 1 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож болно.

-----\*\*\*-----